



**WWF** for a living planet®

## “Дөргөний УЦС” төслийн талаар Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газраас баримталж буй байр суурь

2007 оны 2-р сарын 07, Улаанбаатар хот

Монгол улсын баруун 3 аймгийг найдвартай цахилгааны эх үүсвэрээр хангах асуудлыг шийдвэрлэхийн тулд судалгааны олон ажил хийгдэж хэд хэдэн хувилбар гарсны нэг нь Ховд аймгийн Дөргөн сумын нутагт Чоно-харайх голын хавцлыг боож УЦС барих төсөл юм.



Ховд аймгийн Чоно-харайх голын хавцал, 2006 оны байдал

Чоно-харайх гол нь Хар ус нуурын Байгалийн цогцолборт газрын орчны бүсэд төдийгүй Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гаас тодорхойлсон зайлшгүй хамгаалах шаардлагатай дэлхийн 200 экобус нутгийн нэг болох Алтай-Соёны экобус нутагт оршдог тул тус хөтөлбөрийн газраас 2000 оноос анхаарал хандуулсаар ирсэн билээ.

Энэхүү УЦС-ын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон нийгэм-эдийн засаг, байгаль орчин, хууль эрх зүйн холбогдол бүхий олон асуудлууд хөндөгдөж 2005 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ) хийгдсэнээр төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд удахгүй ашиглалтанд орох дөхөж байна.

Төслийн БОНБНУ-ний үр дүнд байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах зөвлөмж боловсруулан, улмаар “Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө” боловсруулан тодорхой ажлуудыг тодорхой цаг хугацаанд тодорхой хариуцах эзэнтэй зааж өгсөн. Гэвч, өнөөгийн байдлаар эдгээр зөвлөмж болон менежментийн төлөвлөгөөнд заагдсан ажлуудаас хэрэгжиж байгаа нь цөөн, зарим ажлууд нь огт хэрэгжиж эхлээгүй, хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэргүй байсаар байна.

Тиймээс, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар энэ байдалд санаа зовнин, цаашид үүнийг шийдвэрлэх арга замыг төсөл хэрэгжүүлэгч болон бусад холбогдох газруудтай хамтран эрэлхийлэх байр суурь баримталж байна.

Мөн, энэхүү төсөл нь Монголд хэрэгжиж буй бусад УЦС-ын төслүүдэд үлгэр жишээ үзүүлэхүйц түвшинд БОНБНУ хийгдсэнийг анхааран:

1. Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-ний хуулийг дээдлэн энэхүү төслийн хэрэгжилтийг төслийг захиалагч, хэрэгжүүлэгчдийн зүгээс нягт ханган биелүүлэхэд хүчин чармайлт гаргах;
2. Улмаар энэ асуудалд төрийн болон төрийн бус байгууллагууд, ард иргэд идэвхтэй оролцохыг уриалж байна.

**Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар**

Амарын гудамж-4, СБД, хороо-8, Улаанбаатар  
Утас: +976-11- 311659, Факс: +976-11-310237, И-мэйл: [info@wwf.mn](mailto:info@wwf.mn) Вэб: [www.wwf.mn](http://www.wwf.mn)